

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

Нийслэлийн Засаг даргын
Тамгын газрын дарга
Э. Содномжамц

БАТЛАВ.

ГҮЙЦЭТГЭГЧ:

Нутаг консалтинг ХХК-ийн захирал
Н.Шинэболд

**“Багануур үйлдвэрлэл технологийн паркийн захиргаа, нэгдсэн
үйлчилгээний төвийн барилгын зураг төсөл” боловсруулах
зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ**

Дугаар №НХААГ-19/155

2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (цаашид “захиалагч” гэх),
өгөө талаас Нутаг консалтинг ХХК (цаашид “зөвлөх” гэх) нар дараах зүйлийг харилцан
хиролцож 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх)
ийгуулав.

Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох “Ажлын даалгавар болон
үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх)
үзүүлэх үүрэгтэй.

Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин
болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу
үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.

Захиалагч нь “Багануур үйлдвэрлэл технологийн паркийн захиргаа, нэгдсэн
үйлчилгээний төвийн барилгын зураг төсөл” боловсруулах зөвлөх үйлчилгээ
/Дугаар №НХААГ-19/155/ (цаашид “ажил” гэх)-г 32,508,108 /Гучин хоёр сая таван
зуун найман мянга нэг зуун найм/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх)
гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Үүнээс техник
хяналтын зардал 650,162 /Зургаан зуун тавин мянга нэг зуун жаран хоёр/ төгрөг.
Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгоно.

“Багануур үйлдвэрлэл технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний
төвийн барилгын зураг төсөл” боловсруулах №НХААГ-19/155 дугаартай зөвлөх
үйлчилгээг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр эхэлж, 2020 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр дуусган хүлээлгэн өгнө.

Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг”
гэх). Үүнд:

1. Гэрээний ерөнхий нөхцөл;
2. Гэрээний тусгай нөхцөл;
3. Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ
4. Ажиллах хүчин, туслан гүйцэтгэгч, голлох мэргэжилтний ажлын хуваарь

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын
эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг,
хариуцлагыг хүлээнэ.

Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний
бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол
арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.